

УБТЗ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГИЙН СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

Дугаар

202... оны-р сарын-ний өдөр

Улаанбаатар хот

Сүлжээ хоорондын харилцан холболтын энэхүү гэрээ нь Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд, Монгол Улсын холбогдох хуулиуд, Харилцаа холбооны тухай Монгол Улсын хууль, ХХЗХ-ноос батлагдан гарсан харилцан холболтын талаархи холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэсэн болно.

Нэг талаас: “.....” ХХК /цаашид “.....” гэх/ -ийг төлөөлж Гүйцэтгэх захирал

Нөгөө талаас: Монгол - Оросын Хувь Нийлүүлсэн Улаанбаатар Төмөр Зам Нийгэмлэг /цаашид “УБТЗ” гэх/ -ийг төлөөлжнар /хамтад нь “Талууд”, зарим тохиолдолд дангаар нь “Тал” гэх/ доорхи нөхцлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1нь өөрийн үйлчилгээг УБТЗ-ын хэрэглэгчдэд хүргэх, УБТЗ нь өөрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Талууд сүлжээний харилцан холболт хийх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой харилцан холболтын асуудлыг зохицуулахад оршино.
- 1.2. Талууд харилцан холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3. Энэхүү гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.
 1. Үндсэн хэсэг
 - Ерөнхий зүйл
 - Талуудын эрх үүрэг
 - Техникийн нөхцөл
 - Ашиглалт үйлчилгээ
 - Төлбөр тооцоо
 - Хүсэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх тухай
 - Талуудын хүлээх хариуцлага
 - Давагдашгүй хүчин зүйл
 - Гэрээний хугацаа
 - Маргаан шийдвэрлэх
 - Бусад
 2. Хавсралт 1. Харилцан холболтын техникийн үзүүлэлт, Зааглах цэг
 3. Хавсралт 2. Харилцан холболтын зураглал
 4. Хавсралт 3. Харилцан холболтын үйлчилгээний үнэ тариф
 5. Хавсралт 4. Талуудын сүлжээний дугаарлалт
 6. Хавсралт 5. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн хаяг, холбоо барих арга хэрэгсэл
- 1.4 Талууд энэхүү гэрээний хүрээнд дараахь харилцан холболтын үйлчилгээг үзүүлнэ

- Сүлжээ хоорондын дуудлага хийх
- Сүлжээ хоорондын дуудлага хүлээн авах
- Улс хоорондын дуудлага хийх
- Улс хоорондын дуудлага хүлээн авах
- Улс хоорондын гарах дуудлага дамжуулах
- Улс хоорондын орох дуудлага дамжуулах

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Талууд харилцан холболтын гэрээнд дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.1.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаасаа шаардах;
 - 2.1.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;
 - 2.1.3 Өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
 - 2.1.4 Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 7 дугаар зүйлд заасан хариуцлагын механизмыг шат дараатайгаар хэрэглэх.
- 2.2. Талууд харилцан холболтын гэрээнд дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 2.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
 - 2.2.2 Гэрээнд заасны дагуу төлбөр төлөх;
 - 2.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх;
 - 2.2.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг нөхөн төлөх;
 - 2.2.5 Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэх
 - 2.2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүй шалтгааны улмаас харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийх бол Зохицуулах хороонд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний болон гэрээнд оролцогч талын хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
- 2.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай албан бичиг хүргүүлнэ. Албан бичиг хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нь энэхүү гэрээний 7.3-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэнэ.
- 2.4. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг Харилцаа холбооны зохицуулах хороонд тухай бүр хүргүүлж, бүртгүүлж байна.
- 2.5. Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг цуцалж болно. Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухайгаа нөгөө Талдаа 1 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө Тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 2.6. Энэхүү гэрээний 2.3-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж эхэлснээс хойш 14 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нэг талын санаачлагаар гэрээ цуцлах тухай албан тоотыг нөгөө талдаа хүргүүлнэ.
- 2.7. Талууд сүлжээ хоорондын харилцан холболтыг дор дурдсан тохиолдлоос бусад ямар ч тохиолдолд салгалт, хязгаарлалт хийхгүй байна. Үүнд:
 - 2.7.1 Монгол Улсын хууль тогтоомжинд заасан давагдашгүй хүчин зүйлс бий болох;
 - 2.7.2 Аль нэг тал нь харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн;

ГУРАВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт
- 3.1.1 Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байна. Гарсан өөрчлөлтүүдийг гэрээнд нэмэлтээр тухай бүр тусгаж байна.
- 3.1.2 Сүлжээ хоорондын дохиолол нь СС87 байна.
- 3.1.3 Талуудын станцын цагийн синхрончлолын нарийвчлал нь 10^{-11} байна.
- 3.2. Зааглах цэг
- 3.2.1. Сүлжээний зааглах цэгүүдийн байршил Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 3.2.2. Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
- 3.2.3. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-д заасны дагуу байна.
- 3.2.4. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцлийг хангасан байна.
- 3.3. Сүлжээний ачаалал
- 3.3.1. Талууд өөрсдийн холбох шугамын ачааллын хэмжээнд хяналт тавьж, шаардагдах зохицуулалтыг хийж ажиллана.
- 3.3.2. Нэгж шугамд ноогдох ачааллын хэмжээ 0.65 Эрланг /Erlанд/-аас хэтэрсэн тохиолдолд холбох шугамын тоог нэмэх асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.3.3. Харилцан холболтын гэрээний хугацаанд хийгдэх өргөтгөл, өөрчлөлт нь харилцан холбогдогч талуудын сүлжээнд нөлөөлөхүйц байвал энэ талаархи мэдээллийг 3 сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 3.4. Дугаарлалт
- 3.4.1. Талуудын сүлжээний дугаарлалт нь ХХЗХорооноос олгогдсон дугаарлалтын дагуу хийгдэнэ.
- 3.4.2. УБТЗ-ын суурин сүлжээний хэрэглэгчийн дугаарлалт нь Хавсралт 4-д заасны дагуу байна.
- 3.4.3.үүрэн сүлжээний хэрэглэгчийн дугаарлалт нь Хавсралт 5-д заасны дагуу байна.
- 3.4.4. нь УБТЗ-ын сүлжээнд улс хоорондын яриаг 00... гэсэн угтвар дугаартайгаар төгсгөнө.
- 3.4.5. УБТЗ нь-ийн сүлжээнд улс хоорондын яриаг 005 гэсэн угтвар дугаартайгаар төгсгөнө.
- 3.4.6. Талууд сүлжээний дугаар шинээр үүсгэх тохиолдолд нөгөө талдаа ажлын 5 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

ДӨРӨВ. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 4.1. Түрээсийн шугам ашиглахаас бусад тохиолдолд зааглах цэгээс 2 тийш Талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл засварыг хариуцна.
-
- 4.2. Талууд өөрийн сүлжээнд харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг хуанлийн 7 хоногийн өмнө

- урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 4.3. Аль нэг Тал нь нөгөө Талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан Тал нь шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах буюу нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар Талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлнө.
- 4.4. Аль нэг Талын буруутай үйлдлээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах тохиолдолд буруутай этгээд нь нөгөө Тал болон хэрэглэгчийг хохироохгүй байх бүхий л арга хэмжээг /хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт/ авна.
- 4.5. Талууд өөрсдийн сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Аль нэг Талын буруутай үйлдэл, санамсар болгоомжгүй байдлаас, мөн техник технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус халдлага /й'айй/-д өртөх тохиолдолд тухайн Тал нь нөгөө Талд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 4.6. Талууд ашиглалт үйлчилгээний хэвийн нөхцөл алдагдах, гэмтэл саатал гарах тохиолдолд дараах утсанд мэдээлэл өгч хяналт тавьж байна.
- УБТЗ-ын ашиглалт үйлчилгээний утас : 244610, 244653, 244612

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 5.1. Харилцан холболтын төлбөрийг Хавсралт 3 -т заасанаар тооцно.
- 5.2. Талууд тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар харилцан туршилт хийж, баталгаажуулан протокол гаргасан байна.
- 5.3. Харилцан холболтын төлбөрийг хэрэглэгчээс нэхэмжлэхдээ тус тусын үйлчилгээний нөхцлийг баримтлах бөгөөд харилцан холболтын төлбөрийг 1 секундын алхамтайгаар тооцно.
- 5.4. Талуудын төлбөр тооцооны төвийн ажилтнууд харилцан холболт хийгдсэн ярианы өгөгдлийг тухайн тайлант сарын сүүлийн өдрөөс хойш хуанлийн 8 хоногт багтаан электрон хэлбэрээр солилцож, хуанлийн 10 хоногт багтаан тооцоог цаасан дээр хийж баталгаажуулна.
- 5.5. Талуудын ярианы өгөгдлийн зөрүү нь нийт ярианы минутын +/-1%-иас хэтрэхгүй бол Талуудын өгөгдлийн дунджаар харилцан холболтын тооцоог нийлнэ.
- 5.6. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь харилцан холболтын тооцоо нийлсэн өгөгдлийг үндэслэн харилцан холболтын төлбөрийн тооцоог гэрээний 5.4-д заасан хугацаанаас хойш ажлын 3 хоногт багтаан нийлж, илүү төлөлттэй талд нэхэмжлэхийг хүргүүлэх ба төлбөр хариуцагч тал нь нэхэмжлэх хүлээн авснаас хойш харилцан холболтын төлбөрийн зөрүүг НӨАТ-ын хамт төлнө.
- 5.7. Талууд харилцан холболтын тооцоо нийлэх ачааллын өгөгдлийг нөгөө талдаа хүргүүлэхдээ сар сараар ээлжлэн харилцан түрүүлж өгнө.
- 5.8. Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.9. Талуудын сүлжээнд төгсөж байгаа ярианы дугаарлалт тодорхойгүй тохиолдолд уг ярианы минутыг холбох шугамын нэрээр ялгаж тооцоо нийлнэ.
- УБТЗ-ынруу орох, гарах холбох шугамын нэр: 004E, 134E
-УБТЗ руу орох, гарах холбох шугамын нэр:.....
- 5.10. Талуудын тухайн сард харилцан төлөх нийт төлбөрийн 5%-ийг тус тусын Талд орлого цуглуулах шимтгэлд тооцож үлдээнэ.
- 5.11. Төлбөрийн хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөх дүнгийн 0,3%-ийн алданги тооцно.

- 5.12. Аль нэг Тал төгсгөх болон дамжуулах улс, хот хооронд, хотын доторх ярианы үнэ тарифт өөрчлөлт оруулах бол тайлант сар эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө нөгөө Талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

ЗУРГАА. ХҮСЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 6.1. Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор хүссэн Талд гаргаж өгнө. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 6.2. Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрт нь аль болох шуурхай бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариу мэдэгдэнэ.
- 6.3. Талууд өөрийн сүлжээний дугаарлалтад өөрчлөлт оруулах, нөгөө сүлжээнд шинэ чиглэл үүсгүүлэх, чиглэл өөрчлүүлэх, хаах, холбох шугамын тоог нэмэх тухай асуудлыг нөгөө Тал хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хэрэгжүүлнэ. Жич: Тухайн дугаарын өөрчлөлт нь харилцан холболтын төлбөр тооцоотой холбоотой бол талууд энэ талаар харилцан тохиролцсоны дараа хэрэгжүүлнэ.
- 6.4. Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 7.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 7.2. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд учруулсан хохирлоо нөхөн төлөх үүрэгтэй.
- 7.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах дор дурьдсан аргыг шат дараатайгаар хэрэглэнэ. Үүнд:
- 7.3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар мэдэгдэл хүргүүлэх.
- 7.3.2 Энэхүү гэрээний 5.11-т заасны дагуу алданги тооцох;
- 7.3.3 Аль нэг тал нь харилцан холболтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн тохиолдолд 2.2.6 заалтыг хэрэгжүүлэн хязгаарлалт, салгалтыг хийх;
- 7.4. Энэхүү гэрээний 7.3-т заасан арга хэмжээг хүлээсэн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх хууль зүйн үндэслэл болохгүй.
- 7.5. Учирсан хохирол гэдэгт аль нэг талаас гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талаас гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, гэм буруутай тал гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн бол нөгөө талд учрахгүй байсан зарлага зэргийг тооцно.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Хууль тогтоомжинд заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 8.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 8.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн,

эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлуудыг ойлгоно. Энэ талаар зохих байгууллагын дүгнэлт гарсан байвал зохино.

ЕС. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 9.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар гэрээ 202... оны-р сарын ...-ний өдрөөс эхлэн жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2 Гэрээний хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин нэг жилийн хугацаатай сунгагдсанд тооцно.
- 9.3 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, өмчлөл өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээний 1.2-т заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.4 Аль нэг тал төлбөрийн чадамжгүй болж, дампуурсаныг эрх бүхий байгууллагаас зарласан, мөн энэхүү гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусгавар болсон, гэрээнд заасны дагуу хоёр тал харилцан зөвшөөрч гэрээг цуцалсан, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд л энэхүү гэрээг дуусгавар болсон хэмээн Талууд үзнэ.
- 9.5 Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг цуцалж болно. Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухайгаа нөгөө Талдаа 2 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө Тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 9.6 Энэхүү гэрээг дуусгавар болгосон нь уг гэрээний төлбөрийн шаардлага гаргах эрхийг хөндөхгүй бөгөөд шинэ гэрээ байгуулах хүртэлх хугацааны төлбөрийг бүрэн төлж барагдуулна.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1 Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 10.2 Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд аль болох хүлээж авна. Хэрэв Зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Талууд шүүхэд хандах эрхтэй.

АРВАН НЭГ. БУСАД

- 11.1 Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 11.2 Талууд харилцан хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаварыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.
- 11.3 Энэхүү гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 11.4 Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш Харилцан Холболтын ерөнхий журамд заасны дагуу 10 хоногийн дотор талууд хавсралтын хамт ХХЗХ-д хүргүүлж, бүртгүүлнэ.
- 11.5 Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг ХХЗХороонд тухай бүр хүргүүлнэ.
- 11.6 Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор талуудын хооронд оны-р сарын.... -ны өдөр байгуулсан тоот гэрээг хүчингүй болсонд тооцно.

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

..... ХХК:	УБТЗ ХНН: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, Замчны гудамж-1, Ш/Х - 376, УБ - 210535
Утас:.....	Утас: 244607, 244604, 244745
Факс:	Факс: 244607

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“.....” ХХК -ийг төлөөлж:

“УБТЗ” ХНН-ийг төлөөлж:

/Гүйцэтгэх захирал/

/Замын дарга/

” ХХК, УБТЗ
хооронд байгуулсан.....тоот
гэрээний Хавсралт 1

ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	ХХК	УБТЗ
Холболтын байгууламжийн төрөл, марк		/TE 2X110
Дамжуулах/ нягтруулах төхөөрөмж/ байгууламжийн төрөл, марк		2TE XX 8330
Холбох шугамын төрөл, марк, тоо		0703
Интерфейсийн төрөл		120 O1ип

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Зааглах цэгийн байршил	Дохиолол холбооны 2-р анги
Зааглах цэг дэх тоног төхөөрөмж, шугамын төрөл, тэдгээрийн үзүүлэлт, багтаамж	8ИН - 8ТМ % ОИЕ 120 O1ип
Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг хэн хариуцах	Зааглах цэгээс өөрийн талын техник, төхөөрөмжийг талууд өөрсдөө хариуцна.

Хавсралт баталсан:

..... ” ХХК -ийг төлөөлж:

“УБТЗ” ХНН-ийг төлөөлж:


/Гүйцэтгэх захирал/

/Замын дарга/

“.....” ХХК, УБТЗ хооронд
байгуулсан тоот
гэрээний Хавсралт 2

СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ

..... болон Төмөр замын холбооны
төхөөрөмжийг хязгаарлах шугам



Хавсралт баталсан:

..... ” ХХК -ийг төлөөлж:

“УБТЗ” ХНН-ийг төлөөлж:

/Гүйцэтгэх захирал/

/Замын дарга/

“.....” ХХК, УБТЗ хооронд
байгуулсан..... тоот
гэрээний Хавсралт 3

ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

Хот хоорондын харилцан холболтын үнэ тариф

Чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	УБТЗ-д	ХХК-д
.....УБТЗ руу	Үүрэн	Суурин		20 төг	Баланс
УБТЗ-аас.....руу	Суурин	Үүрэн	ТЗХ	Баланс	20 төг

Улс хоорондын ярианы харилцан холболтын үнэ тариф

Ярианы чиглэл	Хаанаас	Хаашаа	Тариф	УБТЗ-д	ХХК-д
.....с УБТЗ-руу	Монголоос	Гадаад /005/	УХ2+50 төг	УХ2	50 төг
	Гадаад /009/	Монгол	ЖМ	20 төг	Баланс
УБТЗ-аас руу	Монгол	Гадаад /009/	УХ1+20 төг	20 төг	УХ1
	Гадаад /005/	Монгол	ТЗХ	Баланс	20 төг

ХХ - ХХ-ын тухайн үйлчилгээний тариф

ТЗХ - УБТЗ-ын тухайн үйлчилгээний тариф

УХ1 --ын улс хоорондын 00Х гарцын ярианы тариф

УХ2 - УБТЗ-ын улс хоорондын 005 гарцын ярианы тариф

Хавсралт баталсан:

.....” ХХК -ийг төлөөлж:

“УБТЗ” ХНН-ийг төлөөлж:

/Гүйцэтгэх захирал/

/Замын дарга/

“.....” ХХК, УБТЗ хооронд
байгуулсантоот
гэрээний Хавсралт 4

УБТЗ-ЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Д/д	Станцын нэрс	Бүсийн код	Станцын дугаарлалт
1	Сүхбаатар өртөө	2362	40000-40999
2	Ерөө	2372	40600-40699
3	Дархан		41100-41299
			41500-41505
			42100-42999
			40800-40899
4	Орхон		43100-43299
5	Дархан-2		
6	Салхит	23742	4100-4499
7	Хөтөл	23651	4500-4699
8	Орхонтуул	23649	46600-46799
9	Эрдэнэт	2352	43000-43299
10	Зүүнхараа	23647	43300-44999
11	Түнх		46100-46299
12	Мандал	22744	4800-4899
13	Мааньт	222	44100-44199
14	Толгойт	21	247200-247399
15	Аршаант	21	246000-246099
16	Улаанбаатар		242000-245999
			252000-255099
17	Хонхор		248800-248899
18	Амгалан	21	248200-248499
19	Багахангай	222	44800-44999
20	Багануур	221	45300-45499
21	Булагтай		
22	Чойр	2542	40000-40999
23	Шивээ-Овоо		
24	Өлзийт		
25	Олон-Овоо		
26	Бор-Өндөр	25241	3200-3299
27	Айраг		4000-4399
28	Сайншанд	2522	42100-43999
29	Өргөн		44300-44399
30	Улаан-Уул		44400-44503
31	Зүүнбаян	25226	4200-4301
32	Замын-Үүд	25245	43000-43999
33	Баян-Түмэн	2582	42000-44000

Үйлчилгээ	Дугаарлалт
Улс хоорондын ярианы гарц	005 гарц

..... -ЫН СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТ

Үйлчилгээ	Дугаарлалт
..... үүрэн холбооны дугаарлалт	xxxx xxxx,
Улс хоорондын ярианы гарц	00х гарц

Хавсралт баталсан:

..... ” ХХК -ийг төлөөлж:

“УБТЗ” ХНН-ийг төлөөлж:

/Гүйцэтгэх захирал/

/Замын дарга/

“.....” ХХК, УБТЗ
ХНН хооронд байгуулсантоот
гэрээний Хавсралт 5

ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ

.....” ХХК-ийн албан тушаалтан холбоо барих арга хэрэгсэл

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			
Техникийн асуудлаар			
Төлбөр тооцооны асуудлаар			

“УБТЗ” -ийн албан тушаалтан холбоо барих арга хэрэгсэл

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар			Утас: Факс: Е-Мэйл:
Техникийн асуудлаар	Дохиолол холбооны 2-р анги	Инженер	Утас: И-Мэйл:
Төлбөр тооцооны асуудлаар	Дохиолол холбооны 2-р анги	Орлогын нягтлан	Утас: Факс: И-Мэйл:
	Дохиолол холбооны 2-р анги	Төлбөр тооцооны инженер	Утас: И-Мэйл: